

## ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

## БУРИАД ДАХЬ ТӨВД СУДЛАЛ

Н.Д. Болсохоева

Буриад дахь дорнодахины судлалын үндсэн чиглэлийн нэг нь Төвд судлал юм.<sup>1</sup> ЗСБНХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын буриадын хэсгийн янз бүрийн тасаг, тухайлбал Буриадын нийгмийн ухааны институт (БНУИ)-ийн гар бичмэлийн хэлтэс, Биологийн институтын сурвалж судлалын лабораторид Төвдийг судлаачид ажиллаж байна.

«Буриад, Монгол, Төвдийн түүх, соёлын дурсгал, сурвалжууд» нь дорнодахинчдын өнгөрөгч таван жилийн судалгааны гол сэдэв байв. Буриадын хэсгийн төвд судлаачдын судалгаа нь юуны өмнө түүх, утга зохиол, урлаг, философи сэтгэлгээ ба хүн эмнэлгийн судлалд зориулагдаж байна. Үгсийн зүйн ажил нэлээд байр эзлэнэ. К. М. Герасимовагийн бүтээлд төвд ба бүддийн судлалын олон асуудал тусгагдсан байна. Тэрээр дорнодахины ард түмний гоо зүйн утга санааны дурсгалыг судалж байна. К. М. Герасимюза төвд тэгийн талаар нэгэн сэдэвт зохиол (Улаан-Үд, 1971) нийтлүүлсэн бөгөөд төвдийн бүддийн ном зохиолоос хөрөг зургийн шастирын судалгааг түүний удирдлагын дор хийв. Тэр одоо шарын шашны зан үйлийн асуудлыг төвд эх сурвалжаар судалж, түүнээсээ нэлээд олныг нь анх удаа эрдэм шинжилгээний эргэлтэд орууллаа. К. М. Герасимова Буриад дахь шарын шашны түүхийг судлаач гол хүний нэг бөгөөд эрдэм шинжилгээний удирдагч юм.<sup>2</sup>

Эртний Энэтхэгийн философич Васубандхугийн «Абхидхар макоша» («илт номын сан») хэмээх бүддийн философийн нэг үндсэн шастирыг Б. В. Семичов, М. Г. Брянский нар оросоор орчууллаа. Энэ шастирын эхний гурван бүлгийг орос орчуулга, төвд эхийн хамт Улаан-Үдэд 1981 онд хэвлэжээ. Б. В. Семичовын бүтээл нь самгарди, пали ба төвд эх зохиолуудад тулгуурлагдсан хийгээд төлөв бүддийн философийн асуудалд зориулагджээ.<sup>3</sup> Б. В. Семичов үгсийн зүйн томоохон судалгаа хийсэн бөгөөд 1963 онд хэвлэгдэж төвдийг судлаачдад үнэлж баршгүй хэрэглэгдэхүүн болсон төвд-орос толь бичгийн зохиогчийн нэг юм. Тэр бас «Ю. Н. Рерихийн самгарди чацуут бүхий «Төвд-англи-орос»

<sup>1</sup> Народы Азии и Африки». 1970, № 5, 237—241-р тал. 1980, № 2. 156— 161-р талд үз.

<sup>2</sup> Жишээ нь К. М. Герасимова. О проблемах исследования традиционной культуры бурят.— Буддизм и средневековая культура Народов Центральной Азии. Новосибирск, 1980 3—1 1-р тал. О некоторых аспектах ассимиляции добуддийских культов по тибетским обрядникам. Мөн тэнд, 54— 82-р талд үз.

<sup>3</sup> Жишээ нь Б. В. Семичов. К вопросу о значении термина «индрия»,—Буддизм и средневековая культура Народов Центральной Азии, 33—39-р талд үз.

толийг хэвлэлд бэлтгэх ажилд Р. Е. Пубаев, Б. Д. Бадараев нарын хамт оролцсон юм. Энэ нөр их чимхлүүр ажлыг Ю. Н. Рерих бүр «Урусвати» Институтэд ажиллаж байхдаа эхэлсэн юм. Б. В. Семичов бас Ю. Н. Рерихийн тольд «Нэмэлт» хийсэн ба 23 мянга орчим үгтэй «Орос-англи-төвд» толь зохиожээ.

Төвдийн түүхийн бичмэл эх сурвалжаар Р. Е. Пубаев, Р. Н. Дугаров нар судалгаа хийж байна. Энэтхэг, Төвд, Хятад болон Монголын улс төр, шашны түүхийг нэн эртний үеэс XVIII зууныг хүртэл тусгасан Сүмбэ-хамбо Ишбалжир (1704—1788)-ын «Пагсам-чжонсан» («горил хангагч галбарва») хэмээх төвдийн түүхийн зохиолыг Р. Е. Пубаев судалж байна. Судалгааны үндэс нь зохиогчийн хийсэн бүрэн тайлбарт орос орчуулга болж байна.<sup>4</sup> Тэрээр Төвдийн түүх болон түүхийн холбогдолтой утга зохиолоор хэд хэдэн өгүүлэл бичжээ.<sup>5</sup> «Наука» хэвлэлийн газрын Сибирийн салбараас хэвлүүлсэн «профессор Г. Ц. Цыбиковын түүвэр зохиол»-ын хоёр ботийг хэвлэлд бэлтгэх асар их ажлыг Р. Е. Пубаев гүйцэтгэв.

Дорнод Төвд (Амдо)-ийн түүхээр «Дэвтэр-чжамцо» («Дэвтэрдалай») хэмээх гурван боть дурсгалыг Р. Н. Дугаров судалж байна. Тэр уг сэдвээр хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн бөгөөд одоо «Дэвтэр-чжамцо» «Амдогийн түүхийн сурвалж бичиг» гэдэг ганц сэдэвт зохиол туурьвиж байна.

Төвдийн ёс суртахуун-сургаалын зохиол<sup>6</sup> Н.Д. Болсохоева, Д. Б. Дашиев, Т. М. Маланова нарын судалгааны сэдэв болж байна. Д. Б. Дашиевын эрдэм шинжилгээний сонирхлын хүрээнд шарын шашны хялбарчилсан сургаалыг төвдийн эх зохиолоор судлах болон Буриадад төвд монгол хэлээр ном хэвлэсэн түүх тус тус багтаж байна. Жура Ёнзиний «Үлгэрт мөрийн зэрэг» гэдэг төвдийн эх бичгийн соёлын дурсгалыг судалсан үндсэн дээр Д. Б. Дашиев няхуур нямбай орчуулга хадсан сонирхолтой өгүүлэл нийтлүүлсэн болно.

«Ганжур, Данжурын судалгааны оршил» хэмээх түүх ном зүй найрууллын хамтын бүтээлийг дорнодахины судлалын хэлтсийн төвдөч нар хийж дуусгав. Түүнд ЗСБНХУ ба хилийн чанадад дахь төвдийн бүддийн шастирын судалгааны түүх, дундад зууны үеийн төвдийн энэхүү өвөрмөц нэвтэрхий толь бичгийг бүтээсэн түүхтэй холбоо бүхий асуудлыг авч үзэн, шастирын бүтэц-үг зүйн шинж чанарыг тодорхойлж Ганжур, Данжурын судалгааны төвд уламжлал, дундад зууны үеийн шинжлэх ухааны ангиллыг тодорхой тайлбарлаж тэрхүү ангиллын дагуу шастир зохиолуудыг шинжлэн судалсан байна.

Төвдийн хүн эмнэлгийн сурвалж судлалыг БНУИ-ийн хүрээнд 1968 оноос эхлэн дорнодахины судлалын биеэ даасан чиглэл болгон эхэлж, ЗХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын хэсгийн Биологийн институтэд үргэлжлүүлэн хийж байна. Их төлөв төвд хэл дээрх эх бичиг судалгааны асуудлаар эрхэлж буй сурвалж судлаачдын үндсэн зорилт нь

<sup>4</sup> Ф. Е. Пубаев. «Пагсам-чжонсан» памятник тибетской историографии XVIII в..» Новосибирск. 1981, 307 хуудас.

<sup>5</sup> Р. Е. Пубаев. Сумба-Хамбо Ешей Бальчжор Историк Центральной Азии. — Рериховские чтения 1969, Новосибирск, 1980, 104—108-р тал. Академик В. П. Васильев первый исследователь тибетской исторической литературы в России. — Востоковедные исследования в Бурятии. Новосибирск, 1981. 62— 78-р тал. История буддийской сиддханти в освещении Сумба-Хамбо в сочинений «Пагсам чжонсан» Буддизм и средневековая культура Центральной Азии, 40—53-р талд үз.

<sup>6</sup> Народы Азии и Африки» 1981. № 4, 166—169-р талд тодорхой бий.

<sup>7</sup> Д. Б. Дашиев. Фольклорные сюжеты в буддийской литературе Тибета. — Буддизм и средневековая культура Народов Центральной Азии. 121 — 144-р тал

эмч, химич, ботаникч, эм зүйн төрөл бүрийн мэргэжилтнүүдэд чухал хэрэгтэй төвд эмнэлгийн онол, практикийн шастируудыг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах явдал болно. Төвд эмнэлгийн нэр томъёоны түлхүүр, түүнийг нэг мөр болгох, төвд эмнэлгийн системийн мөн чанарыг нээн илрүүлэх том ажил сурвалж судлаачдын өмнө тулгарч байна. Мөн тийм ажлын нэг бол эмнэлгийн нэр томъёоны толь зохиох, төвд жорын лавлахуудыг судлах асуудал юм. «Чжуд-ши» («Дөрвөн үндэс»)-ийн 3-р бүлгийн болон «Вайдурья-онбо» («Хөх биндэръя»)-ын «Маннаг-чжуд» («Увдисын үндэс») гэдэг булгүүдийг оросоор орчуулсан нь дээрх чиглэлээр хийсэн анхны туршлага боллоо. Уг бүтээлд тусгай нэр томъёонууд болон ойлголтыг тогтоох, ашиглах хийгээд хэвлэж нийтлэх үр ашигтай хувилбарыг олох оролдлого хийсэн болно.<sup>8</sup>

Төвд эмнэлэг нь ургамал, амьтан, эрдэс минералын гаралтай эмийн зүйлийг их хэрэглэдэг бөгөөд тэдгээрийн тухай эм найруулга, эмчилгээний зэрэг тусгай гарын авлагууд олон байдаг боловч урьд өмнө шинжилж судалсан зүйл хангалттай биш байна. Энэ чиглэлээр А. Ф. Гаммерман, Б. В. Семичов нар асар их ажил хийсэн бөгөөд тэд 737 нэр багтаасан «Төвд эмнэлэгт хэрэглэдэг эмийн зүйлийн төвд-латин-орос нэрийн толь» зохиов.

Төвд эмнэлгийн сурвалж судлалын объект нь гар бичмэлийн санд хадгалагдан буй анагаах ухааны шастирууд болон жорын олон тооны лавлах болно.<sup>9</sup> Төвд эмнэлгийн эх бичгийн бүтэц, системийг Б. Д. Бадараев судалж байна.<sup>10</sup> Тэрээр «Төвд эмнэлгийн зохиолын хэл ба арга маяг» гэдэг ганц сэдэвт зохиол бичиж байна. Төвд эмнэлгийн зохиол «Маннаг Рипчен Чжунгнайг» ч судалж байгаа С. М. Анিকেева уг зохиолыг «жор»-ын бүлэгт хамааруулж түүнийг эмийн жорыг нь хавсаргасан эмчилгээний өвөрмөц гарын авлага хийгээд өвчний ангилал, зарим өвчний шалтгаан, шинж тэмдгийг заасан лавлах бичиг гэж тодорхойлж байна. Төвд эмнэлгийн тодорхой дурсгал бичгүүдийн эрдэм шинжилгээний тайлбар хийх болон шинжлэх ухааны үндэстэй, бүрэн чанартай нэг систем буй болгохын тулд анагаах ухааны шастируудыг судлах нэгдсэн аргачилал боловсруулах талаар С. М. Анিকেева чухал асуудал сэдэж байна.

Эрдэм шинжилгээний ажилтан С. Б. Баторова, К. В. Ракшаин, Л. Л. Хунданова, Э. Г. Базарон нар XVIII зууны монгол эрдэмтэн Жамбалдоржийн «Дзэйцхар Мигчжан» («Үзэсгэлэнт нүдний чимэг») хэмээх төвд эмнэлгийн судрыг судлаад «Төвд эмнэлгийн дурсгал бичиг Дзэйцхар Мигчжан» гэдэг ганц сэдэвт зохиол бичжээ. Дэсрид Санжаажамц (1653—1705)-ын (Вайдурья-онбо) «Хөх биндэръя») гэдэг зохиолын 20-р бүлгийн үндсэн дээр туурвисан бүтээлээ Т. П. Асеева, Э. Г. Базарон нар хэвлэлд шилжүүлэв. Хүн эмнэлгийн сурвалж бичгүүдийн иш баримтыг ашиглан Ц. А. Найдакова, Т. А. Асеева нарын бичсэн «Төвд эмнэлэгт ордог хүнсний ургамал» гэдэг ном «Наука» хэвлэлийн газрын Сибирийн салбарын шинжлэх ухааны хялбарчилсан цувралаар хэвлэгдэнэ.

Төвд эмнэлгийн хөгжлийн түүхийн талаар судалгаа хийж хүнсэнд хэрэглэдэг ургамлын шинж чанар: ургадаг газар, химийн бүрэлдэхүүн, анагаах шинж чанар, шинжлэх ухааны ба ардын эмнэлэгт хэрэглэх тухай зэргийг тодорхойлжээ. «Төвд эмнэлгийн тухай өгүүлэх нь» (Зохиогчид Л. Л.

<sup>8</sup>Б. Д. Бадраев, Э. Г. Бадарон, М. Д. Дашиев, Т. А. Асеева, С. М. Баторово. Лангтабы и их корригирование. Улан-Үдэ, 1976, 121—140-р тал.

<sup>9</sup>Б. Д. Бадараев. О некоторых итогах работ по источниковедению индо-тибетский медицины.— Рериховские чтения. 1979. Новосибирск 1981., 256—259-р тал.

<sup>10</sup>Б. Д. Бадараев. Расшифровка общей структуры и системы «Чжуд-ши»—Востоковедные исследования в Бурятии. 78—92-р тал.

Хунданов, Э. Г. Базарон) гэдэг шинжлэх ухааны хялбарчилсан найруулал 1969 онд, «Энэтхэг-төвд эмнэлгийн сурвалж судлалын судалгааны асуудал» эмхтгэл 1982 онд тус тус хэвлэгджээ. Уг эмхтгэлд Э. Г. Базарон, П. Б. Балданжапов, Н. Д. Болсохосева, М. Г. Брянский В. Э. Назаров-Рытдылон, Е. О. Пинуев нарын төвд эмнэлгийн оросоор хийсэн ном зүй нийтлэгджээ.

«Вайдурья-онбо»-ын гол үндсийг харуулсан «Төвд эмнэлгийн атлас» хэмээх Төвдийн соёлын ховор нандин дурсгалыг сурвалж судлалын лаборатор хэвлэлд бэлтгэж байна. «Атлас» нь Улан-Үд хотын орон нутгийг судлах музейн фондод хадгалагдаж байгаа бөгөөд тэр нь нэр нь үл мэдэгдэх нэг буюу хэд хэдэн зураачид усан будгаар өнгөлж үйлдсэн 76 тооны таблиц зургаас бүрдэнэ. «Атлас» нь төвд эмнэлгийн онол, практикийн үлгэр жишээ сурвалж төдийгүй урлаг судлаач, угсаатны зүйч, бүддийн судлаач, зураач, эмнэлгийн түүх, утга зохиол судлаач, газар зүйч, мифологийн салбарын мэргэжилтэн нарт судалгааны баялаг материал болно. «Төвд эмнэлгийн атлас» нь удиртгал өгүүлэл, дурсгал бичгийн орос орчуулга, тайлбар зүүлтээс бүрдэнэ. «Атлас»-ын таблицыг альбом маягаар хэвлэхээр бодож байна. Н. Б. Балданжаповын удирдлагаар эхэлсэн «Төвд эмнэлгийн атлас»-ын ажлыг одоо түүний бүрэн орос орчуулгыг хийсэн Д. Б. Дашиев, Н. Д. Болсохоева нар үргэлжлүүлж байна. Тэд «Атласын» орос орчуулгандаа төвд, орос, баруун Европын хэл дээрхи бололцоо бүхий ном зохиолыг ашиглан хэл шинжлэлийн тайлбар сэлтийг хавсаргаж анагаахын талын тайлбарыг Э. Г. Базарон бэлтгэжээ. Энэхүү дурсгал бичиг урьд өмнө европын нэг ч хэлээр орчуулагдаагүй ажээ. «Атлас»-ын танилцуулгын хувилбарыг бэлтгэхэд ШУА-ын Дорнодахипы судлалын институтын эрдэм шинжилгээний ажилтан Н. Ц. Мункуев, Ю. М. Парфионович» нар эрдэм шинжилгээ арга зүйн ихээхэн тусламж үзүүлсэн болно.

Сурвалж судлалын лабораторийн ажилтнууд байгаа бүх судраасаа элэгний өрөвслийн холбогдолтой хэсгүүдийг түүвэрлэн орчуулж, туршилгын журмаар хэрэглэх зөвлөмж гаргажээ. Одоо ходоод гэдэсний өрөвслийн талаар төвд эмнэлгийн утга зохиолыг олж судлах, оросоор орчуулах ажлыг хийж байна. Үр ашигтай эмийн зүйл гаргаж авах зорилгоор төвд жорын лавлахуудыг оросоор орчуулж байна. 1903 болон 1908 онд Санкт-Петербуркт хэвлэгдсэн П. А. Бадмаев, А. М. Позднеев нарын эхний хоёр бүлгийн орчуулгыг оролцуулж төвд эмнэлгийн гол шастир «Чжуд-ши»-ийн орчуулгыг эх орны шинжлэх ухааны өнөөгийн ололт амжилтыг ашиглан хийх ажил эхлэн явагдаж байна.

Сурвалж судлалын асар их бааз байгаа нь дорнодахины судлалд чухал ач холбогдолтой юм. БНУИ-ийн гар бичмэлийн хэлтэс дорнодахины хэлүүд, ялангуяа төвд дээрх гар бичмэл болон барын ном судрын цуглуулгаар ЗХУ-д хамгийн баяны нэгд ордог байна. Тэдгээр цуглуулга нь жил бүрийн экспедицийн олбор үнэт шинэ материалаар сэлбэгдсээр байна. Гар бичмэлийн хэлтэст түүх, соёл, утга зохиол, хэл, урлаг, философи, анагаах ухааны талаар их хэмжээний төрөл бүрийн сурвалж бичгүүд хадгалагдаж байна. Эдгээр материал нь зөвхөн төвдийн ард түмнийхээр барахгүй Төв Азийн ард түмний оюуны амьдралын бараг бүх талыг хамарч байна. Институтын төвд фондод Будон (1290—1364), Төвдийн соёлын түүхийн хөгжилд асар нөлөөлсөн гэлүмба ёсны үндсийг тавигч Зонхава (1357—1419), Хайдав Гэлэгбалсан (1385—1438), Цахар гэвш Лувсанцүлтэм (XIX зуун), Сүмба Хамбо Ишбалжир (1704—1788), Туган Лувсан Чойжинням (1737—1802), Лондоллам Агваанлубсан (1719 онд төрсөн), Гончог Данбидонмэ (1762—1823) зэрэг нэрт хүмүүсийн сүмбүм (Бүрэн зохиолын эмхэтгэл) хадгалагдаж

байна. Далай лам, Банчин лам нарын сүмбүм фондын цуглуулгын чухал хэсэг болно. Бүддийн ном судрыг самгарди хэлнээс төвд рүү орчуулж бурхан шашин номлохоор төвдөд уригдсан энэтхэгийн алдарт эрдэмтэн Адиша (1982—1054)-гийн зарим зохиолууд цуглуулгад байхаас гадна тэнд Бромдонба (1004—1065), Бодова (1027—1105), сажийн таван эрдэмтэн, төвдийн нэрт эрдэмтэн тавдугаар далай ламын засаг баригч Дэсрид Санжаажамц (1653—1705)-ын шастирууд, XIX зууны төвдийн эрдэмтэн Гончог Дамбаравжаа (1801 онд төрсөн)-гийн «Дэвтэр-чжамцо» («Дэвтэр-далай») хэмээх гурван боть түүхийн зохиол зэрэг олон тооны ном судар байна.

Гар бичмэлийн фондод нь ховор нандин лавлах хэрэглэгдэхүүн, төвд хэлний олон янзын тайлбар толь, төвд-монгол толь, түүний дотор төвдийн бүддийн ном зохиолыг монгол хэл рүү орчуулахад зориулсан төвд-монгол нэр томъёоны толь бичиг «Мэргэд гарахын орон»-ы бээжин ба буриад хэвлэл хүндтэй байр эзлэнэ. Энэхүү толь бичиг бол монголын бүддийн нэр томъёо, төвдөөс монгол руу орчуулах дүрэм боловсруулах тусгай комиссын асар их бэлтгэл ажлын үр дүн юм. «Мэргэд гарахын орон» (Даяг хайв жунай) толийн Барамид ба вумын аймаг Улан-Үдэд 1960 онд хэвлэгдэв.

Ганжур, Данжур (Ганжур нь тухайн хэвлэлээс шалтгаалж 100—108 боть, Данжур 225 боть) хэмээх төвдийн бүддийн утга зохиолын хоёр их цоморлиг соёлын үнэт дурсгалд багтана. Цуглуулгад Ганжур, Данжурын янз бүрийн хэвлэл байна. Бүддийн ном шастирууд нь төвд судлалын нэн чухал сурвалж болдог юм. Эдгээр дурсгал бичгүүдийг эх орны шинжлэх ухааны үүднээс шүүмжлэлтэйгээр задлан шинжлэх явдал Ганжур, Данжурын янз бүрийн хуулбарыг харьцуулан судлахад чухал ач холбогдолтой бөгөөд төвдөд бүддийн ном зохиол үүссэн тухай асуудлыг зөв шийдвэрлэх боломж олгоно.

Гар бичмэлийн хэлтэст төвд эмнэлгийн маш сонирхолтой ховор надин цуглуулга байна. Төвд эмнэлгийн номыг хоёр ангид хувааж үздэг.

1. Төвд эмнэлгийн үндсэн шастир «Чжуд-ши» («Дөрвөн үндэс»), 2. «Ужуд-ши»-ийн олон тооны тайлбар буюу эмчилгээний янз бүрийн аргыг хэрэглэх гарын авлага ба анагаах ухааны шастирын үндсэн дээр зохиосон жорын лавлахууд. Тэнд бас төвд эмнэлгийн онол, практикийг багтаасан «Чжуд-ши»-ийн янз бүрийн хэвлэл, түүний монгол орчуулга хадгалагдаж байна. Германы эрдэмтэн В. Хайссигийн бичсэнээр «Чжуд-ши»-г монголоор анх XIV зууны үед Чойжи-Одсэр орчуулжээ «Чжуд-ши» нь шүлгийн хэлбэрээр бичсэн дөрвөн ботиос бүрдэнэ. Тэр нь төвд эмнэлгийн үнэт сурвалж бөгөөд төвд эмнэлгийн баялаг өв уламжлалыг танин мэдэх зорилгод иж бүрэн судалгаа болно. «Чжуд-ши»-ийн тайлбар дотроос хамгийн доривтой нь «Вайдурья- онбо» («Хөх биндэрья») нэрт дэлгэрэнгүй бөгөөд чамбай тайлбар юм. Энэ судрыг Дэсрид Санжаажамц 1688 онд зохиожээ. «Вайдурья-онбо» 156 бүлэгт хуваагдах дөрвөн ботиос бүрдэх бөгөөд бүтцийнхээ хувьд «Чжуд-ши»-тэй бүрэн дүйцэнэ. Эмхтгэлд «Лхантаб», «Маннаг Гарчжаб» («Нууц увдис»), эм судлал, найруулгын шүлэгт судрууд, Данзан Пунцагийн «Шэлпрэн» ба «Шелгон» зэрэг өргөн хэмжээгээр оржээ. (Эдгээр шастирыг Б. Д. Бадараев, Б. Н. Батуев, Ж. Жапов нар оросоор орчуулж байна).

Сүмба-Хамбо, Цахар гэвш нарын зохиолын бүрэлдэхүүнд эмнэлгийн зохиол ордог байна. Энэтхэгийн эрдэмтэн Дашийн үзэж байгаагаар төвдөөр орчуулсан сонгомол аюурвед эмнэлгийн 22 судар нь Данжурын хэсэг болно. Эртний Энэтхэг эмнэлгийн судраас Данжурт оруулсан нь төвд нар энэтхэгийн эмчлэх ухааны ололтыг ихээхэн сонир

хож байсныг гэрчилж байна. Эртний энэтхэг эмнэлгийн самгарди судрууд нэгэнт үрэгдсэн учир Данжурт орсон эмнэлгийн зохиолууд нь эртний энэтхэгийн анагаах ухааны чухал бичмэл сурвалж болдог байна. Төвд эмнэлгийн онцлогийг ойлгох, улмаар анагаах ухааны түгээмэл түүхэнд төвд эмч нарын оруулсан хувь нэмрийг үнэлэхэд энэтхэгийн эрдэмтэн-эмч нарын зохиолыг төвд эмнэлгийн эх зохиолуудтай харьцуулсан судалгаа их нэмэртэй.

Төвд гар бичмэл ба модон барын баялаг цуглуулгын судалгаагаар ЗХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын Буриадын эрдэм шинжилгээний цогцолбор институт (БЭШЦИ)-ын эрдэмтэд, 1966 оноос ЗХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын хэсэг тус тус ажиллаж ирэв. БЭШЦИ-ээс төвд гар бичмэл, модон барын хоёр эмхтгэл (эмхтгэл 1. М. 1960 эмхтгэл 2, 1965), «Гүнчин Жамъян Шадавдоржийн зохиолын тайлбар 1649—1723» (Улан-Үд, 1962)-ыг тус тус хэвлүүлжээ. Одоо төвд фондыг данслах, товъёглох ажил хийгдэж байна.

БНУИ-ийн төвд судлаачдын өмнө төвд цуглуулгын эрдэм шинжилгээний каталогийг бэлтгэн хэвлүүлэх хариуцлагатай зорилт зогсож байна. Каталогт тусгагдсан Төв Азийн ард түмний соёлын түүхийн үнэт мэдээ сэлтийн үндсэн дээр уг районы ард түмний түүх, утга зохиол, хэл, философи сэтгэлгээ, урлаг, эмнэлэгтэй холбогдсон эрдэм шинжилгээний янз бүрийн асуудлын иж бүрэн судалгаа хийх боломжтой болно.

Гар бичмэлийн хэлтсийн төвд цуглуулгын онц сонин дурсгалуудыг илрүүлэн судлах ажил явагдаж байгаа бөгөөд энэ нь төвдийн өвөрмөц соёлын шинж чанарыг тодруулж Төв Азийн дундад зууны соёлд түүний эзлэх байр суурь, роль үүргийг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой юм.

Манайд болон гадаад орнуудад зохиогддог эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумд Буриадын төвд судлаачид оролцож байна. Дорнодахины судлалаар эрдэм шинжилгээний төлөвлөгөөг зохицуулагч төв болох ЗХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын институттай зөвлөлтийн ШУА-ийн Буриадын салбар шинжлэл судлалын ажлаа нягт холбоотой явуулдаг юм. Дорнодахины судлалын өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд ЗХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын институт, түүний Ленинградын салбар үнэт туслалцаа үзүүлдэг юм.

БНМАУ-ын ШУА-ийн хүрээлэнгүүд, Монгол улсын их сургууль, Энэтхэгийн соёлын олон улсын Академи, түүнчлэн социалист болон капиталист орны эрдэмтэдтэй Буриадын төвд судлаачид эрдэм шинжилгээний холбоотой байдаг. Гадаадын дорнодахинч, эрдэмтэд, өмнөд, зүүн өмнөд Ази хийгээд Японоос бүддийн төлөөлөгчид Буриадын салбарт ирж айлчилдаг болно.

«Народы Азии и Африки» сэтгүүлийн 1983 оны  
№ 2-оос орчуулсан Э. ПУНЦАГ